



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 18

Арвайхээр

Орон нутгийн өмчийн тооллогын
дүнгийн тухай

Орон нутгийн өмчийн тооллогын дүнгийн тухай Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч М.Отгон, Аж ахуйн нярав Ж.Ганзориг нарын сонсголыг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Сумын орон нутгийн засаг захиргааны байгууллагын үндсэн хөрөнгө 2016 оны дүнгээр 36.000.365.480 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18.1.3-ийн “л” заалт, аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 3.3.3, 3.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн тооллоготой холбогдуулан байгууллагын актлах хөрөнгийн жгсаалтыг нэгдүгээр хавсралтаар, шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, дуудлага худалдаанд оруулах хөрөнгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийтийн зориулалтай өмчийг холбогдох хуулийн дагуу ашиглаж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч /О.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.АМАРТҮВШИН